



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/17

Өвт

Эцэг эхийн зөвлөл байгуулах тухай

Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3, 26 дугаар зүйлийн 26.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолын хавсралтаар “Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллах зөвлөмж”-ийн 2.2, 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын Эцэг эхийн зөвлөлийг дараахь бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга: О.Отгонтуяа (Санхүүгийн албаны дарга)

Нарийн бичгийн дарга: Г.Дуламдорж (Насан туршийн боловсролын арга зүйч)

Гишүүд: Г.Доржханд (Хууль эрх зүйн мэргэжилтэн)

Ж.Нямтогтох (Багийн Засаг дарга)

Ө.Гөлгөө (Улсын бүртгэгч)

2. Засаг даргын Тамгын газрын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг тогтворжуулан зөвлөмжийг мөрдөж, төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг зохион байгуулж, тайланг жилийн бүрийн 12 дугаар сарын 01-ны дотор аймгийн Гэр бүл хөгжлийн газарт хүргүүлж ажиллахыг Зөвлөлийн дарга (О.Отгонтуяа)-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 18-ний өдрийн “Гэр бүлийн зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай” А/08 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Н.БАТ-ЭРДЭНЭ

627202059

D:My Doc A-4 tushaal /ZDTG/